



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН 2021 ОНЫ
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/16/НА-СТА-ТТЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Ц.Хосжаргал
Утас: 261628 Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn
Ахлах аудитор: Л.Нямтөмөр
Утас: 261740 Цахим хаяг: nyamtumurl@audit.gov.mn
Аудитор: С.Бат-эрдэнэ
Утас: 261740 Цахим хаяг: bat-erdenes@audit.gov.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	6
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	8
3. Аудитын тайлан	9
3.1 Ерөнхий зүйл	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
4. Аудитын илрүүлэлт	16
4.1 Залруулсан алдаа	16
4.2 Зөвлөмж	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ШШҮХ	Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн
ЭМД	Эрүүл мэндийн даатгал



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН
ЗАХИРАЛ, ЦАГДААГИЙН ХУРАНДАА
Б.БОЛДБААТАР ТАНАА

2022.03.25 № 01/413
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийж гүйцэтгэлээ.

Татварын ерөнхий газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн нэгтгэсэн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ



Я.САРАНСҮХ

2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/			
Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	869,105.2	817,641.4
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	56,029.2	41,175.8
33	АВЛАГА	215,881.5	429.8
34	УРЬДЧИЛГАА	375.3	0.0
35	БАРАА МАТЕРИАЛ	596,819.2	776,035.8
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	13,411,781.4	13,045,548.2
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	13,411,781.4	13,045,548.2
39200	Биет хөрөнгө	12,524,687.8	12,153,206.1
39300	Биет бус хөрөнгө	887,093.6	892,342.1
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	0.0	0.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	14,280,886.6	13,863,189.6
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	39,390.0	4,665.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	39,390.0	4,665.0
41300	Өглөг	4,570.0	3,345.0
41400	Урьдчилж орсон орлого	34,820.0	1,320.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	14,241,496.6	13,858,524.5
51	Засгийн газрын хувь оролцоо	14,241,496.6	13,858,524.5
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	6,132,218.7	6,143,933.7
51200	Хуримтлагдсан үр дүн	3,021,166.8	2,626,479.8
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5,088,111.0	5,088,111.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	14,280,886.6	13,863,189.6

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/			
Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	14,271,699.9	14,924,697.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,671,710.8	806,536.8
120	Нийтлэг татварын бус орлого	1,671,710.8	806,536.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	12,599,989.2	14,118,161.0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	13,458,928.7	15,294,315.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	13,458,928.7	15,294,315.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	13,120,029.2	14,510,434.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	8,361,037.7	9,363,727.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	264,857.3	245,944.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	286,383.3	314,018.3
2104	Хангамж, бараа материалын зардал	498,119.9	648,080.5
2105	Норматив зардал	1,778,854.1	1,742,755.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	172,309.4	195,269.2
2107	Томилолт, зочны зардал	70,192.5	77,105.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	296,522.7	172,798.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,391,752.2	1,750,734.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	338,899.5	783,881.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	0.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	812,771.2	(369,617.6)
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.0	0.0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	899,745.0	25,069.4
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(86,973.8)	(394,687.0)

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	14,307,204.4	0.0	14,307,204.4
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,049.9	0.0	1,049.9
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	14,308,254.3	0.0	14,308,254.3
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	20,216.0	0.0	20,216.0
9	Тайлант үеийн үр дүн	(86,973.8)	0.0	(86,973.8)
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	14,241,496.6	0.0	14,241,496.6
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0	0.0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	14,241,496.6	0.0	14,241,496.6
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0	0.0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	11,715.0	0.0	11,715.0
19	Тайлант үеийн үр дүн	(394,687.0)	0.0	(394,687.0)
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	13,858,524.5	0.0	13,858,524.5

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	13,194,448.9	14,685,617.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	594,459.7	352,666.8
120	Нийтлэг татварын бус орлого	594,459.7	352,666.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	12,599,989.2	14,332,951.0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	12,563,423.1	13,699,506.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	12,563,423.1	13,699,506.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	11,860,051.8	12,915,625.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	8,357,372.5	9,366,231.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	264,121.4	245,787.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	286,156.8	313,045.2
2104	Хангамж, бараа материалын зардал	485,104.4	626,475.7
2105	Норматив зардал	1,676,191.3	1,717,492.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	246,799.5	257,599.3
2107	Томилолт, зочны зардал	82,964.9	77,105.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	315,698.7	215,418.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	145,642.4	96,470.1
211	ХҮҮ	0.0	0.0
212	ТАТААС	0.0	0.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	703,371.3	783,881.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	631,025.8	986,111.0
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	0.0	0.0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	622,095.9	1,000,964.5

22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	622,095.9	1,000,964.5
2200	Дотоод эх үүсвэрээр	622,095.9	1,000,964.5
2260	Гадаад эх үүсвэрээр	0.0	0.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(622,095.9)	(1,000,964.5)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.0	0.0
14	Бусад эх үүсвэр	0.0	0.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.0	0.0
24	ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР	0.0	0.0
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	0.0	0.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	8,929.8	(14,853.4)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	47,099.4	56,029.2
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	56,029.2	41,175.8

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	13,488,088,900.00	13,452,034,047.65	36,054,852.35	99.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	13,488,088,900.00	13,452,034,047.65	36,054,852.35	99.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	12,884,303,400.00	12,848,248,557.65	36,054,842.35	99.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	9,383,764,400.00	9,362,013,072.16	21,751,327.84	99.8
210101	Үндсэн цалин	5,237,603,300.00	5,431,311,100.43	(193,707,800.43)	103.7
210102	Нэмэгдэл	3,422,738,100.00	3,309,660,481.06	113,077,618.94	96.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	723,423,000.00	621,041,490.67	102,381,509.33	85.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	249,644,200.00	245,787,214.87	3,856,985.13	98.5
210201	Тэтгэврийн даатгал	60,621,300.00	61,894,622.33	(1,273,322.33)	102.1
210202	Тэтгэмжийн даатгал	7,242,300.00	6,449,279.26	793,020.74	89.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,100,000.00	4,989,053.33	110,946.67	97.8
210204	Ажилгүйдлийн даатгал	1,185,500.00	935,164.24	250,335.76	78.9
210205	Эрүүл мэндийн даатгал	175,495,100.00	171,519,095.71	3,976,004.29	97.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	314,788,600.00	307,206,384.19	7,582,215.81	97.6
210301	Гэрэл, цахилгаан	92,648,000.00	89,278,377.96	3,369,622.04	96.4
210302	Түлш, халаалт	156,958,800.00	153,741,032.45	3,217,767.55	97.9
210303	Цэвэр, бохир ус	49,216,800.00	48,227,273.78	989,526.22	98.0
210304	Байрны түрээс	15,965,000.00	15,959,700.00	5,300.00	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	617,035,000.00	616,329,782.23	705,217.77	99.9
210401	Бичиг хэрэг	107,731,800.00	108,135,223.00	(403,423.00)	100.4
210402	Тээвэр, шатахуун	275,268,900.00	274,629,648.00	639,252.00	99.8
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	57,630,300.00	57,350,492.23	279,807.77	99.5
210404	Ном, хэвлэл	5,587,000.00	5,587,000.00	0.00	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	23,667,100.00	23,381,500.00	285,600.00	98.8
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	147,149,900.00	147,245,919.00	(96,019.00)	100.1
2105	Норматив зардал	1,602,624,500.00	1,602,578,498.70	46,001.30	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	977,487,700.00	977,462,023.70	25,676.30	100.0
210502	Хоол, хүнс	73,638,800.00	73,618,500.00	20,300.00	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	551,498,000.00	551,497,975.00	25.00	100.0

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	435,224,700.00	435,216,649.00	8,051.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	356,138,800.00	356,135,160.00	3,640.00	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	57,559,500.00	57,555,119.00	4,381.00	100.0
210604	Урсгал засвар	21,526,400.00	21,526,370.00	30.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	77,161,000.00	76,451,610.00	709,390.00	99.1
210702	Дотоод албан томилолт	77,161,000.00	76,451,610.00	709,390.00	99.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	200,245,600.00	198,849,946.50	1,395,653.50	99.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	137,656,800.00	137,531,225.50	125,574.50	99.9
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,186,000.00	1,186,000.00	0.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	11,963,800.00	11,744,807.00	218,993.00	98.2
210804	Тээврийн хэрэгслийн татвар	4,957,800.00	4,274,619.00	683,181.00	86.2
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	999,200.00	935,354.00	63,846.00	93.6
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	19,690,500.00	19,690,500.00	0.00	100.0
210807	Газрын төлбөр	5,259,900.00	4,955,841.00	304,059.00	94.2
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	18,531,600.00	18,531,600.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,815,400.00	3,815,400.00	0.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,815,400.00	3,815,400.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	603,785,500.00	603,785,490.00	10.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	603,785,500.00	603,785,490.00	10.00	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	580,351,600.00	580,351,590.00	10.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	23,433,900.00	23,433,900.00	0.00	100.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0	0	0.00	0
220001	Барилга байгууламж	0	0	0.00	0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0	0	0.00	0
230001	Эргэж төлөгдөх зээл	0	0	0.00	0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	13,488,088,900.00	13,496,207,441.65	(8,118,541.65)	100.1
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	13,220,188,900.00	13,182,306,747.65	37,882,152.35	99.7
310001	Улсын төсвөөс санхүүжих	13,220,188,900.00	13,182,306,747.65	37,882,152.35	99.7
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	267,900,000.00	313,900,694.00	(46,000,694.00)	117.2
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	267,900,000.00	313,900,694.00	(46,000,694.00)	117.2
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	9,000.00	(9,000.00)	0.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	9,000.00	(9,000.00)	0.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	23	23	0.00	100.0
610001	Төсвийн байгууллага	23	23	0.00	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	594	593	1.00	99.8
620001	Удирдах ажилтан	23	23	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	555	554	1.00	99.8
620003	Үйлчлэх ажилтан	16	16	0.00	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		1,112,762,054.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ		983,777,890.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		901,372,327.16
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		4,218,339.26
210101	Үндсэн цалин		688,481.00
210102	Нэмэгдэл		1,729,858.26
210104	Урамшуулал		1,800,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		5,838,800.00
210303	Цэвэр, бохир ус		118,800.00
210304	Байрны түрээс		5,720,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал		14,539,321.00
210401	Бичиг хэрэг		1,675,480.00
210402	Тээвэр, шатахуун		1,390,490.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		149,650.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		11,323,701.00
2105	Норматив зардал		115,587,053.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		114,747,053.00
210502	Хоол, хүнс		840,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		367,352,349.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		228,625,100.00
210602	Тавилга		3,765,320.00
210604	Урсгал засвар		134,961,929.00
2107	Томилолт, зочны зардал		654,000.00
210702	Дотоод албан томилолт		654,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		20,538,884.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		20,314,459.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		151,323.00
210807	Газрын төлбөр		73,102.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		372,643,580.90
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		372,643,580.90
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		82,405,563.74
2132	Бусад урсгал шилжүүлэг		81,410,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		81,410,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		995,563.74
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		995,563.74
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		128,984,164.00
2200	Дотоод эх үүсвэрээр		128,984,164.00
223001	Бусад хөрөнгө		70,481,664.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		58,502,500.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		1,112,762,054.90
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		1,112,762,054.90
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		818,623,844.90
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		291,518,310.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад анхан шатны баримтын бүрдүүлэлтийг сайжруулах, дотоод хяналтыг сайжруулах талаар өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 03 дугаар сарын 05-аас 2022 оны 03 дугаар сарын 25-ны хооронд ахлах аудитор Л.Нямтөмөр, аудитор С.Бат-Эрдэнэ гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ц.Хосжаргал, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Монгол Улсын ерөнхий аудиторов орлогч Я.Сарансүх нар хэрэгжүүлсэн.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 01/1341 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Шүүхийн шинжилгээний байгууллага нь 2021 онд “Байгууллагын эрх зүйн орчныг боловсронгуй болгон, үйл ажиллагааг цахимжуулж, албан хаагчдын мэргэжлийн ур чадвар, ажиллах нөхцөл, удирдлагын манлайллыг дээшлүүлнэ” гэсэн зорилтыг тавьж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил хэрэгжүүлэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирлын баталсан “Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн 2021 онд хийх дотоод аудит, албаны шалгалтын төлөвлөгөө”-ний дагуу дотоод аудитын чиглэлээр 7, төлөвлөгөөт шалгалтын ажлаар 7 арга хэмжээг төлөвлөсөн байна.

Төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний хүрээнд харьяа газар, хэлтсийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, удирдлагад танилцуулж, зөвлөмж өгч ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын зорилго оршино.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, 14,358.7 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 143.6 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 417.7 сая төгрөгөөр буюу 2.9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс авлага, үндсэн хөрөнгө, өр төлбөр данснүүдэд материаллаг өөрчлөлт гарсан байна.

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 41.2 сая төгрөг болж, өмнөх оноос 14.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

			/мянган төгрөг/	
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	
Касст байгаа бэлэн мөнгө	-	17,541.0	17,541.0	
Банканд байгаа бэлэн мөнгө	56,020.2	23,625.8	(32,394.4)	
Дүн	56,029.2	41,175.8	(14,853.4)	

Эх сурвалж: Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 17.5 сая төгрөг касст, 23.6 сая төгрөг төрийн сангийн харилцах дансанд байршиж байна.

Аудитын илрүүлэлт:

И-баримтгүй болон зөрүүтэй дүнгээр 19.3 сая төгрөгийн ажил, гүйлгээг бүртгэсэн /Говь-Алтай аймгийн ШША 0.3 сая, Сүхбаатар аймгийн ШША 2.4 сая, Ховд аймгийн ШША 1.9 сая, Нийслэлийн шүүхийн шинжилгээний газар 0.7 сая, Сэлэнгэ аймгийн ШША 8.6 сая, Төв аймгийн ШША 3.5 сая, Ховд аймгийн ШША 1.9 сая/

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 0.4 сая төгрөг болж, өмнөх оноос 215.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2 . Авлагын үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагсадтай холбогдсон авлага	480.5	325.3	(155.1)
Төлбөртэй үйлчилгээний авлага	68.7	-	(68.7)
Татаас, санхүүжилтийн авлага	214,790.0	-	(214,790.0)
Байгууллагаас авах авлага	542.3	104.4	(437.9)
Хувь хүмүүсээс авах авлага	542.31	0.00	(542.3)
Дүн	215,881.5	429.8	(215,451.7)

Эх сурвалж: Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэл буурсан нь өмнөх онд үүссэн татаас санхүүжилтийн авлага барагдсан нь нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт:

- Говь-Алтай аймгийн ШША төсвийг зохистой удирдаагүйгээс 0.2 сая төгрөгийн авлага үүсгэсэн;
- Архангай аймгийн ШША түлш халаалтын зардлыг нэхэмжилсэн дүнгээс 1.3 сая төгрөгөөр илүү шилжүүлснийг санхүүгийн тайланд авлагын үлдэгдлээр тайлагнаагүй.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа данс өмнөх оноос 375.0 сая төгрөгөөр буурч, үлдэгдэлгүй болсон байна.

Хүснэгт 3. Урьдчилгаа дансны үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	375.3	-	(375.3)
Дүн	375.3	-	(375.3)

Эх сурвалж: Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өмнөх онд урьдчилж гарсан зардлаар бүртгэсэн 375.3 сая төгрөгийн ажил, гүйлгээг тайлант онд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 776.0 сая төгрөг болж, өмнөх оноос 179.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	222,547.1	120,737.7	(101,809.4)
Эм боох	16,746.2	72,894.9	56,148.7
Бичиг хэргийн материал	11,750.1	18,377.5	6,627.5
Аж ахуйн материал	42,112.3	80,277.6	38,165.3
Сэлбэг хэрэгсэл	15,812.1	15,904.2	92.1
Түлш, шатах тослох материал	13,471.2	24,250.3	10,779.1
Барилгын засварын материал	51.5	2,411.7	2,360.2
Хүнсний материал	3,720.0	18,179.0	14,459.0
Бусад хангамжийн материал	270,608.8	423,003.0	152,394.2
Дүн	596,819.2	776,035.8	179,216.6

Эх сурвалж: Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны үлдэгдлийн өсөлтөд бусад хангамжийн материал 152.4 сая, эм боох материал 56.1 сая, аж ахуйн материал 38.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

Бараа материал худалдаж авсан 2,449.0 сая, үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 154.6 сая, нийт 2,603.6 сая төгрөгөөр нэмэгдэж, үйл ажиллагаанд зарцуулсан 2,422.6 сая, шилжүүлсэн 1.7 сая, нийт 2,424.4 сая төгрөгөөр хасагджээ.

Аудитын илрүүлэлт:

Орхон аймгийн ШША 4.0 сая төгрөгийн тээвэр шатахуун зарцуулахдаа анхан шатны баримтын бүрдэл хангаагүй, шатахууны тооцоог нормоор бодож баталгаажуулаагүй, 2.4 сая төгрөгийн бараа материалыг бөөн дүнгээр зарлагдсан.

3.5.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 13,045.5 сая төгрөг болж, өмнөх оноос 366.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	12,524.7	12,153.2	(371.5)
Барилга, байгууламж, орон сууц	8,800.7	8,788.5	(12.3)
Авто-тээврийн хэрэгсэл	742.6	614.0	(128.7)
Машин тоног төхөөрөмж(компьютер)	2,703.3	2,405.3	(298.0)
Тавилга, аж ахуйн эд хогшил	230.3	234.1	3.8
Бусад үндсэн хөрөнгө	47.6	40.9	(6.8)
Дуусаагүй барилга байгууламж	-	70.5	70.5
Биет бус хөрөнгө	887.1	892.3	5.2
Программ хангамж	44.0	31.6	(12.4)
Бусад биет бус хөрөнгө	843.1	860.7	17.6
Дүн	13,411.8	13,045.5	(366.2)

Эх сурвалж: Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд худалдаж авсан 897.0 сая, үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 389.9 сая төгрөгөөр нэмэгдэж, ТӨБЗГ-ын шийдвэрээр 22.0 сая төгрөгийн тээврийн хэрэгслийг дуудлага худалдаагаар борлуулсан дүнгээр хасагдсан байна.

Аудитын илрүүлэлт:

Баянхонгор аймгийн ШША орон нутгийн төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 40.0 сая төгрөгийн автомашиныг Орон нутгийн өмчийн газартай ашиглалтын гэрээ байгуулаагүй;

3.5.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 4,665.0 сая төгрөг болж, өмнөх оноос 34,725.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагсадтай холбоотой өглөг	3,983.3	524.6	(3,458.7)
Бараа үйлчилгээний зардлын өглөг	165.0	814.0	649.0
Байгууллагад төлөх өглөг	395.2	2,006.4	1,611.2
Хувь хүмүүст төлөх өглөг	26.5	-	(26.5)
Барьцаа, дэнчингийн урьдчилж орсон орлого	34,820.0	1,320.0	(33,500.0)
Дүн	39,390.0	4,665.0	(34,725.0)

Эх сурвалж: Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд урсгал зардалтай холбоотой 0.5 сая, бараа үйлчилгээний 0.8 сая, байгууллагад төлөх 2.0 сая төгрөгийн өглөг, түрээслэгчийн 1.3 сая төгрөгийн барьцааны урьдчилж орсон орлого бүртгэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

Төсвийг зохистой удирдаагүйгээс 1.5 сая төгрөгийн өр төлбөр үүсгэсэн. /Говь-Алтай аймгийн ШША 1.2 сая, Говьсүмбэр аймгийн ШША 0.3 сая/

3.5.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 13,858.5 сая төгрөг болж, өмнөх оноос 0.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо

/ мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал	6,132.2	6,143.9	11.7
Хуримтлагдсан үр дүн	3,021.2	2,626.5	(394.7)
Өмнөх үеийн үр дүн	3,108.1	3,021.2	(87.0)
Тайлант үеийн үр дүн	(87.0)	(394.7)	(307.7)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5,088.1	5,088.1	0.0
Дүн	14,241.5	13,858.5	(383.0)

Эх сурвалж: Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл өссөн нь тайлант оны үр дүн эерэг үзүүлэлттэй гарсан нь нөлөөлсөн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2021 оны төсвийн төслийн нийт зарлагыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 24,170.4 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсөв захирагчид хүргүүлсэн байна.

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулиар төсөв захирагчийн нийт зарлагыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 13,483.1 сая төгрөгөөр баталж, 2021 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар 5.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 13,488.1 сая төгрөгөөр тодотгожээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Нийт зарлагын 13,220.2 сая төгрөгийг улсын төсвөөс, 267.9 сая төгрөгийг үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 13,220.2 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгосон байна. Үндсэн үйл ажиллагааны орлого 313.9 сая төгрөг бүрдүүлж, төлөвлөснөөс 46.0 сая төгрөгөөр давсан байна.

Төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн гүйцэтгэл 13,452.0 сая төгрөг буюу 99.7 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны урсгал зардлаас дутуу зарцуулснаас шалтгаалсан байна. Зарцуулагдаагүй үлдэгдэл болон давсан орлого 82.1 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Хүснэгт 9. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Хөтөлбөр арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Код	Нэр			
70707	Шүүхийн шинжилгээ	13,488,088.9	13,452,034.0	36,054.9
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	12,746,646.6	12,710,717.3	35,929.3
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	603,785.5	603,785.5	-
80220	Холбооны суваг ашигласны хөлс	39,305.0	39,305.0	-
82311	Шүүхийн шинжилгээний тусгай ажил үйлчилгээний төлбөр	98,351.8	98,226.2	125.6

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 9.6 сая, аймаг, нийслэлийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 818.6 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд нэмэлт орлого 284.5 сая, нийт 1,112.8 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Үүнээс урсгал зардалд 1,111.8 сая төгрөгийг зарцуулж, 1.0 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

Аудитын илрүүлэлт:

- Дундговь аймгийн ШША албан томилолтын зардлыг 0.6 сая төгрөгөөр зөрүүтэй тооцож олгосон;
- Нийслэлийн шүүхийн шинжилгээний газар 2.0 сая төгрөгийн цалинг илүү тооцож олгосон;
- Төсвийн зохицуулалт хийх зөвшөөрөлгүйгээр 13.4 сая төгрөгийг бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан /Өмнөговь аймгийн ШША 4.9 сая, Увс аймгийн ШША 3.4 сая, Хөвсгөл аймгийн ШША 3.1 сая, Хэнтий аймгийн ШША 2.0 сая /

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

“Монгол Улсын Шүүхийн шинжилгээний байгууллагын хүчин чадлыг сайжруулах 18.5 сая ам.долларын өртөгтэй төсөл”-ийн ерөнхий хэлэлцээрийн гэрээг МУ-ын Сангийн яам болон Хууль зүй, дотоод хэргийн яамны удирдлагууд, Монгол дахь Эксим банкны төлөөлөгчид 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдөр гарын үсэг зурж баталгаажуулсан бөгөөд БНСУ-ын Засгийн газраас 2021 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 121/19 тоот албан бичгээр санхүүжилт олгох тухай “Батламж” авсан байна.

3.8 Аудитын гол асуудал

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан үзүүлэлтийн зорилтот түвшинд 10 зорилтын хүрээнд 108 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталснаас, гүйцэтгэлээр 99.0 хувийн биелэлттэй байна.

3.9 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх

дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн нь шилэн дансны цахим хуудсанд 149 мэдээлэл байршуулахаас 124 мэдээллийг хугацаанд, 11 мэдээллийг хугацаа хоцроож, 14 мэдээллийг байршуулаагүй байна. Үүнд: Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний 3 дугаар сарын мэдээллийг, төсөв, өмч хөрөнгө мөнгө зарцуулах, өр авлага үүсгэх аливаа шийдвэрийн 8 дугаар сарын мэдээллийг хугацаа хоцроосон, батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгааны 4 дүгээр улирал болон бүтэн жилийн мэдээллийг, өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлангийн бүтэн жилийн мэдээллийг, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 2 гүйлгээний 185.0 сая төгрөг, зарлагын 7 гүйлгээний 193.4 сая төгрөгийн, таван сая төгрөгийн дээш үнийн бүхий худалдан авалтын 10 гүйлгээний 366.4 сая төгрөгийн мэдээллийг мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.4, 6.4.5-д заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хуулийн хугацаанд мэдээлэл байршуулж хэвших, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх талаар албан шаардлага өгсөн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

Харьяа байгууллагуудад илэрсэн нийцлийн аудитын асуудлаар илэрсэн нийт 1,155.2 сая төгрөгийн зөрчил илэрснээс 861.1 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 294.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмжийг өгсөн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Харьцуулалтын аргаар 116.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй урсгал засварын 3 ажлыг гүйцэтгэх компанийг сонгох шалгаруулахдаа tender.mn сайтад ил тод байршуулж, зохион байгуулаагүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4-т “Захиалагч урилгыг энэ хуулийн 52.1, 12-т заасан цахим хуудсанд байрлуулж, тендер шалгаруулалтын дүнг тухай бүр мэдээлнэ”, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.4.3-т “худалдан авах ажиллагааны бодлого, төлөвлөлтийг сайжруулж, ил тод болгох олон нийтээр урьдчилан хэлэлцүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх” гэж заасантай тус тус нийцэхгүй, Үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу tender.mn цахим хуудсанд ил тод зарлаж, олон нийтийн оролцоог хангаж, зохион байгуулах, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага өгөхөөр шийдвэрлэсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, худалдан авах ажиллагаатай холбоотой дээрх асуудал нь ТБОНӨХБАҮХАТХуулийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж үзлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2021 оны эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 99.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага, 39.6 сая төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлсэн ба тайлант онд зөрчил давтагдан гарсан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

ШШҮХ нь Сортчоно ХХК-тай 2020 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн ШШҮХ2020/05 дугаартай гэрээ байгуулж 44 м.кв талбайг эмнэлгийн шинжилгээ, оношилгооны зориулалтаар түрээслүүлсэн боловч түрээслэгч тал 2021 оны 6-12 сарын түрээсийн 10.1 сая төгрөгийн төлбөр төлөөгүй, талбайг чөлөөлүүлээгүй байна. Тус газраас 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдөр 04/1537 албан бичгээр Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргасан байна. Иймд дараагийн аудитаар түрээсийн төлбөрийг төлүүлж, байгууллагын эзэмшлийн талбайг чөлөөлүүлсэн эсэхийг дахин хянан үзнэ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 359.8 сая төгрөгийн 63 алдаа, зөрчил илэрснээс, 233.8 сая төгрөгийн 25 алдааг залруулж, 5.1 сая төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт тогтоож, 92.6 сая төгрөгийн зөрчилд 12 албан шаардлага хүргүүлж, 28.3 төгрөгийн алдаа, зөрчилд 22 зөвлөмж хүргүүллээ.

Залруулагдаагүй нийт алдаа, зөрчил 126.1 сая төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшин 143.6 сая төгрөгөөс бага тул “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн.

4.1 Харьяа байгууллагууд

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 23 төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 21 байгууллагад дүгнэлт гаргаж, 2 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 21 дүгнэлт өглөө.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 359.8 сая төгрөгийн 63 алдаа, зөрчил илэрснээс, 233.8 сая төгрөгийн 25 алдааг залруулж, 5.1 сая төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт тогтоож, 92.6 сая төгрөгийн зөрчилд 12 албан шаардлага хүргүүлж, 28.3 төгрөгийн алдаа, зөрчилд 21 зөвлөмж хүргүүллээ.

Түүвэрт хамрагдсан байгууллага

Залруулга

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах залруулгыг хийлээ. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн данснаас 22.0 сая төгрөгийн ажил, гүйлгээг шууд зардалд бүртгэсэн;
- Бараа материалын зарцуулалтыг данс буруу ангилж, санхүүгийн үр дүнгийн тайланд 99.9 сая төгрөгийн зардлыг үйл ажиллагааны бус зардлаар тайлагнасан.

Албан шаардлага

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн төсөвт зохицуулалт хийх зөвшөөрөлгүйгээр ЭМД, НДШ-ийн зардлаас цалингийн зардалд 14.1 сая, хоолны зардлаас нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 18.9 сая, тээвэр шатахууны зардлаас урсгал засварын зардалд 2.4 сая, нийт 35.4 сая төгрөгийг гүйлгэн зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал

ашиглах заавар”, 2018 оны 134 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам"-ын 3.1.6-д "... дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрлийг албан бичгээр авсан байх" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хууль болон холбогдох журам зааврыг зөрчиж төсвийн эдийн засгийн ангиллыг бүлэг хооронд шилжүүлсэн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан албан шаардлага өгөхөөр шийдвэрлэсэн.

Зөвлөмж

1.1 Илрүүлэлт:

Бараа материалын орлого, зарлагын баримтад үйлдсэн, зөвшөөрсөн, хүлээн авсан хүний гарын үсэг зураагүй, анхан шатны баримтыг баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна." гэсэн заалттай нийцээгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Бараа материалын орлого, зарлагын анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгасан холбогдох албан тушаалтны гарын үсгийг зуруулж, баталгаажуулан ажил гүйлгээг бүртгэж байх.

4.2 Төсвийн төвлөрүүлэн захирагч

Зөвлөмж

1.1 Илрүүлэлт:

ШШҮХ-ийн харьяа байгууллагуудын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 202.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 111.8 сая төгрөгийн алдааг залруулж, 5.1 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 57.2 сая төгрөгийн зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага, 28.4 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-т "Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 15.4.1-т "төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх", 14.2.2-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох", 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 14.2.5-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах" гэж заасантай бүрэн нийцэхгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүү, төсвийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтын тогтолцоо, үйл ажиллагааг сайжруулж, аудитаар илэрсэн алдаа, зөрчилд дүн шинжилгээ хийж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар нэгдсэн арга хэмжээг авч хэрэгжүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

5.1 Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Аудитын санал дүгнэлтийн төрөл					Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс								
			Бүгд	Үүнээс						Залруулга		Акт		Албан шаардлага		Зөвлөмж		
				Зөрчилгүй	Хязгаар-лалттай	Сөрөг	Дүгнэлт агахаас	Түүвэрт хамруулсан	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийн төвлөрүүлэн захирагч																		
1	Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн	АХГ-2022/16/НА-СТА-ТТЗ	1	1					1	-						1	-	
Дүн			1	1					1	-						1	-	
Төсвийн төвлөрүүлэн захирагч																		
1	Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн	АХГ-2022/328/НА-СТА-ТШЗ	1					1	5	157,347.5	2	121,917.6			1	35,429.9	2	-
2	Архангай аймгийн Шүүхийн шинжилгээний алба	АРА-2022/157-НА-СТА-ТШЗ	1	1					3	3,658.9	1	2,400.0	1	1,258.9			1	-
3	Баян-Өлгий аймгийн Шүүхийн шинжилгээний алба	БӨА-2022/165/НА-СТА-ТШЗ	1	1					-	-								
4	Баянхонгор аймгийн Шүүхийн шинжилгээний алба	БНА-2022/103/НА-СТА-ТШЗ	1	1					1	40,000.0					1	40,000.0		
5	Булган аймгийн Шүүхийн шинжилгээний алба	БУА-2022/123/НА-СТА-ТШЗ	1	1					2	159.5							2	159.5
6	Говь-Алтай аймгийн Шүүхийн шинжилгээний алба	ГАА-2022/71/-НА-СТА-ТШЗ	1	1					4	3,586.9	2	2,222.5			1	1,364.4	1	-
7	Дорноговь аймгийн Шүүхийн шинжилгээний алба	ДГА-2022/111/НА-СТА-ТШЗ	1	1					6	46,838.0	3	46,838.0					3	-
8	Дорнод аймгийн аймгийн Шүүхийн шинжилгээний алба	ДОА-2022/178/НА/СТА-ТШЗ	1	1					2	860.3					2	860.3		
9	Дундговь аймгийн Шүүхийн шинжилгээний алба	ДУА-2022/10/НА-СТА-ТШЗ	1					1	2	926.5	1	338.8	1	587.7				
10	Завхан аймгийн Шүүхийн шинжилгээний алба	ЗАА-2022/193/СТА - ТШЗ	1	1					1	3,338.7							1	3,338.7
11	Өвөрхангай аймгийн Шүүхийн шинжилгээний алба	ӨВА-2022/124/НА-СТА-ТШЗ	1	1					2	1,200.0					1	1,200.0	1	-
12	Өмнөговь аймгийн Шүүхийн шинжилгээний алба	ӨМА-2022/117/НА-СТА-ТШЗ	1	1					4	25,645.5	3	20,728.3					1	4,917.2
13	Сүхбаатар аймгийн Шүүхийн шинжилгээний алба	СБА-2022/22/НА-СА-ТШЗ	1	1					4	16,267.7	2	13,881.8			1	2,385.9	1	-

14	Сэлэнгэ аймгийн Шүүхийн шинжилгээний алба	СЭА-2022/243/НА-СТА-ТШЗ	1	1				3	11,485.7	1	1,608.5	1	1,257.9			1	8,619.3	
15	Төв аймгийн Шүүхийн шинжилгээний алба	ТӨА-2022/17/-НА-СТА-ТШЗ	1	1				3	5,056.4	1	1,580.2			1	3,476.2	1	-	
16	Увс аймгийн Шүүхийн шинжилгээний алба	УВА-2022/46/НА-СТА-ТШЗ	1	1				1	3,382.5					1	3,382.5			
17	Ховд аймгийн Шүүхийн шинжилгээний алба	ХОА-2022/34/НА-СТА-ТШЗ	1	1				3	10,597.3	1	8,747.3					2	1,850.0	
18	Хөвсгөл аймгийн Шүүхийн шинжилгээний алба	ХӨА-2022/262/НА-СТА-ТШЗ	1	1				1	3,098.1							1	3,098.1	
19	Хэнтий аймгийн Шүүхийн шинжилгээний алба	ХЭА-2022/07/НА-СТА-ТШЗ	1	1				2	2,427.9	1	452.9			1	1,975.0			
20	Дархан-Уул аймгийн Шүүхийн шинжилгээний алба	ДАА-2022/129/НА-СА-ТШЗ	1	1				-	-									
21	Орхон аймгийн Шүүхийн шинжилгээний алба	ОРА-2022/17/НА-СТА-ТШЗ	1	1				2	6,365.8							2	6,365.8	
22	Говьсүмбэр аймгийн Шүүхийн шинжилгээний алба	ГСА-2022/21/СТА-ТШЗ	1	1				9	14,929.3	7	13,046.2			1	1,883.1	1	-	
23	Нийслэлийн шүүхийн шинжилгээний газар	НТАГ-2022/274/НА-СА-ТШЗ	1	1				2	2,671.1			1	1,970.2	1	700.9			
Дүн			23	21	-	-	-	2	62	359,843.6	25	233,762.1	4	5,074.7	12	92,658.2	21	28,348.6
Нийт дүн			24	22	-	-	-	2	62	359,843.6	25	233,762.1	4	5,074.7	12	92,658.2	22	28,348.6

5.2 Нийцлийн аудитын асуудлаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:			
					Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн	АХГ-2022/328/НА-СТА-ТШЗ	2	861,045.9	2	861,045.9		
2	Булган аймгийн Шүүхийн шинжилгээний алба	БУА-2022/123/НА-СТА-ТШЗ	1	-			1	-
3	Завхан аймгийн Шүүхийн шинжилгээний алба	ЗАА-2022/193/СТА-ТШЗ	1	-	-	-	1	-
4	Сүхбаатар аймгийн Шүүхийн шинжилгээний алба	СБА-2022/22/НА-СА-ТШЗ	1	165,684.8			1	165,684.8
5	Төв аймгийн Шүүхийн шинжилгээний алба	ТӨА-2022/17/-НА-СТА-ТШЗ	1	-		-	1	
6	Хэнтий аймгийн Шүүхийн шинжилгээний алба	ХЭА-2022/07/НА-СТА-ТШЗ	1	128,421.5			1	128,421.5
	ДҮН		7	1,155,152.2	2	861,045.9	5	294,106.3



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 25 № 705/А0160054
АХГ-2022/16/НА-СТА-ТТЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.Үүнд:

Харьцуулалтын аргаар 116,253,800.00 төгрөгийн төсөвт өртөгтэй урсгал засварын 3 ажлыг гүйцэтгэх компанийг сонгох шалгаруулахдаа tender.mn сайтад ил тод байршуулж, зохион байгуулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4 “Захиалагч урилгыг энэ хуулийн 52.1, 12-т заасан цахим хуудсанд байрлуулж, тендер шалгаруулалтын дүнг тухай бүр мэдээлнэ”, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.4.3 “худалдан авах ажиллагааны бодлого, төлөвлөлтийг сайжруулж, ил тод болгох олон нийтээр урьдчилан хэлэлцүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх” гэж заасантай тус тус нийцэхгүй, Үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тшаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу tender.mn цахим хуудсанд ил тод зарлаж, олон нийтийн оролцоог хангаж, зохион байгуулах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг ШШҮХ-ийн захирал, цагдаагийн хурандаа Б.Болдбаатар, Ерөнхий нягтлан бодогч, Санхүү төлөвлөлт, хангамжийн газрын дарга, Цагдаагийн ахмад Г.Оюунбат нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Л.НЯМТӨМӨР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 25 № 406/А0160057

Улаанбаатар хот

АХГ-2022/16/НА-СТН-ТТЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.Үүнд:

Шүүхийн шинжилгээний байгууллагын хэмжээнд шилэн дансны цахим хуудсанд нийт 3381 удаагийн давтамжтайгаар мэдээллийг бүрэн байршуулсан боловч 115 мэдээллийг хуулийн хугацаанд мэдээлээгүй байна.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн тухайд шилэн дансны цахим хуудсанд 149 мэдээлэл байршуулахаас 124 мэдээллийг хугацаанд, 11 мэдээллийг хугацаа хоцроож, 14 мэдээллийг байршуулаагүй байна.

Үүнд: Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний 3 дугаар сарын мэдээллийг, төсөв, өмч хөрөнгө мөнгө зарцуулах, өр авлага үүсгэх аливаа шийдвэрийн 8 дугаар сарын мэдээллийг хугацаа хоцроосон, Батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгааны 4 дүгээр улирал болон бүтэн жилийн мэдээллийг, өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлангийн бүтэн жилийн мэдээллийг, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 2 гүйлгээний 185,000,000.00 төгрөг, зарлагын 7 гүйлгээний мэдээллийн 193,397,230.00 төгрөгийн, таван сая төгрөгийн дээш үнийн бүхий 10 худалдан авалтын 366,694,893.00 төгрөгийн мэдээллийг мэдээлээгүй байна.


Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.4, 6.4.5-д заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааны журмыг буруу сонгож, төсөвт өртгийг хуваасан зөрчлийг арилгах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг ШШҮХ-ийн захирал, цагдаагийн хурандаа Б.Болдбаатар, Ерөнхий нягтлан бодогч, Санхүү төлөвлөлт, хангамжийн газрын дарга, Цагдаагийн ахмад Г.Оюунбат нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Л.НЯМТӨМӨР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 25 № 707/А0160057
АХГ-2022/16/НА-СТБ-ТТЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.2-д заасны дагуу Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.Үүнд:

Төсөвт зохицуулалт хийх зөвшөөрөлгүйгээр ЭМД, НДШ-ийн зардлаас цалингийн зардалд 14,131,900.00 төгрөгийг, хоолны зардлаас нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 18,900,000.00 төгрөгийг, тээвэр шатахууны зардлаас урсгал засварын зардалд 2,398,000.00 нийт 35,429,900.00 төгрөгийг гүйлгэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар", 2018 оны 134 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам"-ын 3.1.6-д "... дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрлийг албан бичгээр авсан байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн тухай хууль болон холбогдох журам, зааврыг зөрчиж, төсвийн эдийн засгийн ангиллыг бүлэг хооронд шилжүүлсэн зөрчлийг арилгах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг ШШҮХ-ийн захирал, цагдаагийн хурандаа Б.Болдбаатар, Ерөнхий нягтлан бодогч, Санхүү төлөвлөлт, хангамжийн газрын дарга, Цагдаагийн ахмад Г.Оюунбат нарт дааллав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.КОСЖАРГАЛ
Л.НЯМТӨМӨР

[illegible]